



**ХОРГО ХАЙРХАН ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЗЭМШИГЧДЭД**

**ПРОУТ ФИНАНС АУДИТ ХХК**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Төвдэлж, 10-дугаар хороо,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 15110, Монгол Улс  
Телефон: 7711 1111, 7711 1112, 7711 1113, 7711 1114, 7711 1115  
Тайвны утас: 7711 1116, 7711 1117, 7711 1118, 7711 1119, 7711 1120  
Тайвны факс: 7711 1121, 7711 1122, 7711 1123, 7711 1124, 7711 1125

Огноо 2019.03.27 Дүгнэлт 02/15

**Хараат бус аудиторын тайлан**

***Дүгнэлт***

Бид Хорго хайрхан ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайланг жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, амгийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон өг хөлболол бүхий нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, тус компанийн санхүүгийн тайлан нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайланг жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

***Дүгнэлтийн үндэслэл***

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (шашид АОУС гэх)-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагаудын дагуу компанийг хараат бус бөгөөд элгээр шаардлагаудын дагуух ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

***Хараат бус байдал***

Нягтлан бодогчдын олон улсын стандартын зөвлөл (НБОУЭСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (МНБЭЗД)-ийн дагуу Компаниас бид хараат бус болно. Бид НБОУЭСЗ-ийн МНБЭЗД-ийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

*Аудитын арга барил*

*Хүраангуй*

Материаллаг байдлын түвшин	Компанийн материаллаг байдлын түвшин 878.3 мянган төгрөг бөгөөд энэ нь нийт хөрөнгийн дүнгийн 1 хувьтай тэнцүү байна.
Аудитын гол асуудал	Компанийн шинэ зохион байгуулалттай холбоотой асуудал

Бид энэхүү материаллаг байдлын түвшинг тодорхойлж, санхүүгийн тайлангуудад материаллаг буруу илэрхийлэл байх эрсдлийг тооцсоны үндсэн дээр аудитаа төлөвлөсөн. Тухайлбал бид удирдлагын хийсэн томоохон тооцоолуудыг үнэлсэн бөгөөд үүний нэг жишээ нь тодорхой бус ирээдүйн үйл явдлын талаар таамаглалыг агуулсан бизнес төлөвлөгөөг үнэлэх явдал юм. Мөн гүйцэтгэх удирдлагын хяналтын орчинд нөлөөлөх байдал буюу эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих үйлдлүүд болон залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг багтах нотолгоо бий эсэхийг авч үздэг.

Бид аудитын цар хүрээгээ компанийн үйл ажиллагаа эрхлэх салбар, бүртгэл хөтлөлт, хяналтын системийг багтаав санхүүгийн тайлангуудыг бүхэлд нь дүгнэхэд хангалттай нотолгоо өгөхүйц, бэлэнд үр дүнтэй ажиллах боломж олгох байдлаар тодорхойлсон болно.

*Материаллаг байдил*

Бидний аудитын цар хүрээнд материаллаг байдал нөлөөлдөг ба аудит нь санхүүгийн тайлангууд бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлээс ангид гэсэн үндэслэлтэй баталгаа гаргахад зориулагдсан. Буруу тайлагнал нь алдаа эсвэл залилангаас үүсч болох бөгөөд энэ нь тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд үндэслэн хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр байвал материаллаг хэмээн тооцогдоно.

Бид өөрсдийн мэргэжлийн үнэлэмжинд үндэслэн компанийн санхүүгийн тайланд бүхэлд нь хамаарах ерөнхий материаллаг байдлын босгыг тогтоосныг доорх хүснэгтэд харуулав.

Эдгээрийг чаварын бусад хүчин зүйлүүдийн хамт харгалзан үзсэнээр бид аудитын гүйцэтгэх хугацаа, горимуудын цар хүрээг тогтоож буруу илэрхийлэл бий бол тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд хэрхэн нөлөөлөхийг тодорхойллоо.

Компанийн материаллаг байдлын түвшин	878.3 мянган төгрөг
Тодорхойлохдоо авигласан арга	Нийт хөрөнгийн нэг хувь
Материаллаг байдлыг түвшинг тооцсон үндэслэл	Компани нь сүүлийн жилүүдэд үйл ажиллагаа явуулаагүй ба нийт хөрөнгийн дүн тогтвортой байсныг жишээ үзүүлэлт болгон авсан. Бидний сонгосон нэг хувь нь энэ төрлийн компаниудын хувьд хүлээн зөвшөөрөгдөх материаллаг байдлын түвшинд багтаж байгаа болно.

*Аудитын гол асуудал*

Аудитын гол асуудал гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжийн хувьд тухайн тайланг хугацааны санхүүгийн тайлангуудад хамгийн чухал нөлөө үзүүлэхүүнд зүйлсийг хэлнэ. Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайлангуудыг аудитлах явдал болон аудитын дүгнэлт өгөхдөө харгалзан үздэг бөгөөд тусад нь нэмэлт дүгнэлт гаргадаггүй болно.



### **Аудитын гэл асуудал**

*Компанийг нэгтгэлд үүссэн зохион байгуулалттай холбоотой асуудал*

Монгол даатгал ХХК нь Хорго хайрхан ХК-ийн энгийн хувьцааны 81.35 хувийг эзэмшиж, Хорго хайрхан ХК-ийг Монгол даатгал ХХК-д нэгтгэх замаар өөрчлөн байгуулах шийдвэрийг Хорго хайрхан ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэсэн. Үүнтэй холбогдуулан дээрх 2 компанийг нэгтгэхтэй холбоотой баримт бичгүүд болон компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг баталсан ба дүрмийн 14.1-т зааснаар Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, хурал оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор баталж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэнээр хүчин төгөлдөр болохоор заасан. Дүрмийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар баталсан хэдий ч Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлээгүй байх тул аудитын дүгнэлт гаргах өдрийн байдлаар уг дүрэм хүчин төгөлдөр болоогүй байна.

### **Бидний аудит эдгээр асуудлыг хэрхэн авч үзсэн тухай**

Бид аудитын явцад компанийн нэгтгэх үйл ажиллагааны талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, уг шийдвэрийн дагуу гаргасан гэрээ, журам, шинэчилсэн дүрэм зэрэгтэй танилцаж, мөн тэдгээр нь хуульд нийцэж байгаа эсэх талаарх Үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий этгээдийн гаргасан хууль зүйн дүгнэлт, холбогдох нотлох баримтуудтай танилцсан.

Компанийн тухай хуулийн 17.9-д "Компанийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлт, шинэчлэл найруулсан дүрэм нь улсын бүртгэлд бүртгэгснээр хүчин төгөлдөр болно" гэж заасан.

Даатгалын тухай хуулийн 21.5-д "Даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг даатгаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмших, өмчлөхийг хүсэгч нь ийнхүү эзэмших, өмчлөх тохиромжтой этгээд гэж үзсэн тохиолдолд Зохицуулах хороо даатгагчид зөвшөөрөл олгоно" гэж заасны дагуу Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрөл олгох үед компанийн шинэчилсэн дүрмийг улсын бүртгэлд бүртгэх нөхцөл бүрдэхээр байна.

### **Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал**

АОУС 570, 2-р зүйл: "Тасралтгүй бийх зарчмын дагуу байгууллага өөрийн бизнесийг ойрын ирээдүйд үргэлжлүүлнэ гэж үздэг. Хэрэв удирдлага байгууллагыг татан буулгах, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохоор төлөвлөж байгаа, эсвэл тэгэхээс өөр ямар ч боломжгүй байхаас бусад тохиолдолд ерөнхий зориулалттай санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэдэг."

Ойрын ирээдүй гэдэг нь аудитын аялалт кийгдэж буй балансын өдрөөс хойш нэг жилийн хугацааг илтгэнэ.

Тасралтгүй үйл ажиллагааны төсөөлөл нь санхүүгийн тайлан бэлтгэх үндсэн зарчим нь бэлдэх тул аж ахуйн нэгжийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварыг гүйцэтгэх удирдлага үнэлэх шаардлагатай байдаг.

### **Компанийн удирдлагын үзгээс:**

"Монгол Даатгал" ХХК болон "Хорго Хайрхан" ХК-ийн 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлагдсан нэгтгэх журам, дүрэм, гэрээг "Санхүүгийн зохицуулах хороо"-ноос хянаж үзээд, гадаадын хөрөнгө оруулагчтай компанийн талаар "Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар"-т тодорхой заалт байхгүй учир уг зааврыг шинэчлэх хүртэл хоёр байгууллагын нэгтгэх ажиллагааг түр хойшлуулсан. 2018 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 208 дугаар тогтоолоор Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар шинэчлэгдэн батлагдсан тул 2019 онд бид Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хоёр компанийг нэгтгэх асуудлыг шинэ хэлэлцэх ба 2019 оноос нэгтгэх үйл ажиллагаа дуусч "Хорго Хайрхан" ХК-ийн үйл ажиллагаа хэвийн явагдаж эхэлнэ гэж үзсэн.

### *Аудиторын үгээс:*

Санхүүгийн тайлан бэлтгэхэд удирдлагын ашигласан тасралтгүй үйл ажиллагааны төсөөллийн тохиромжтой байдалтай холбоотой хангалтгүй, зохистой аудитын нотолгоо цуглуулж, цуглуулсан аудитын нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүй үйл ажиллагаа үргэлжлүүлэн явуулах чадварт томоохон эргэлзээ үүсгэх үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг байдал бий эсэхийг судалж үзэхэд компанийн нэгтгэх үйл ажиллагаа хуулийн дагуу явагдсан ба Санхүүгийн Зохицуулах Хорооноос зөвшөөрөл олгосноор тасралтгүй хэвийн үргэлжлэх үндэслэлтэй байна.

### *Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага*

Удирдлага нь санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (иашид СТОУС гэх)-ын дагуу бэлтгэж, үнэн зөв тооилуулах үүрэг, хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг алдаанаас ангид санхүүгийн тайланг бэлтгэхэд зайлшгүй шаардлагатай дотоод хяналтыг тодорхойлох үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх компанийн чадамжийг үнэлж, тодруулах, шаардлагатай бол компанийг татан буулгахаар, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохоор, эсвэл нэгтгэхээ өөр бодит хувилбар байхгүйгээр төлөвлөснөөс бусад тохиолдолд тасралтгүй ажиллагаатай холбоотой асуудал болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй ажиллагааны зарчмыг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг хариуцлага хүлээнэ.

### *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх Аудиторын үүрэг хариуцлага*

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ захиран эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үл үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг багтаасан тайлан гаргах юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-н дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг байна гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтлээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

Бид АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар мэргэжлийн шүүмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх ханглагыг баримтлан ажилладаг ба бид,

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, уг эрсдлийг үнэлэн, эрсдэлд тохиромжтой аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг



- Ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үл үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чаламжид мэдэгдэхүйц эргэлтээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материалыг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгал анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг.

Гэхлээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүйд хүргэж болно.

- Тодруулгыг багтаагаад санхүүгийн ерөнхий тодруулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв тогилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйцгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголцлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилддаг.



Грунт Финанс Аудит ХХК  
Монгол Улс, Улаанбаатар 14200,  
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Бага тойруу,  
Эзэн Чингисханы нэрэмжит талбай-5,  
Сити Тауэр 901 тоот

2019 оны 3 дугаар сарын 27-ны өдөр

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг санхүүгийн тайлан болон тодруулгал материаллаг нөлөө үзүүлж болох юм. Уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгалгүйг анхаарна уу

